



## ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.06.04-06.08

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** АНУ-ын компаниудын хувьцааны ханш худалдааны маргаан болон бусад геополитикийн нөхцөл байдлаас үл хамааран өсөлттэй хаагдлаа.

S&P 500 индексийн сагсанд багтдаг өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш АНУ-ын Засгийн газрын бондын өгөөж нэмэгдсэнтэй холбогдуулан унав.

АНУ-ын долларын ханш еврогийн эсрэг сулран тус улсын экспортлогч компаниудын ашгийг нэмэгдүүлжээ. Энэ долоо хоногт G-7 орнуудын уулзалт болж өнгөрсөн билээ.

Мөн АНУ болон Хойд Солонгосын тэргүүнүүдийн уулзалт хөрөнгө оруулагчдийн анхаарлыг ихээр татаж байна.

**Европ:** АНУ-ын Ерөнхийлөгч Канад болон Европын холбооны улсууд шударга бус худалдааны хориг тавьж байна хэмээн буруутгаснаар Европын компаниудын хувьцааны ханш унасан байна.

АНУ ган, хөнгөн цагааны импортод тариф ногдуулсан хэвээр байх эсэх асуудал Европын хөрөнгө оруулагчдын анхаарлыг татав.

Итали улсад шинээр Засгийн газар байгуулагдсантай холбогдуулан FTSE MIB индекс унажээ.

Испани улсын Ерөнхий сайд Педро Санчез Европын засгийн газрыг байгуулахаар болсон нь тус улсын IBEX 35 индексийг өсгөв.

**Япон:** Японы компаниудын хувьцааны ханш 2.36%-аар өсөж 22,694.50 хүрч хаагджээ. Иений ханш ам.долларын эсрэг 109.4 нэгжид хүрсэн нь 2017 оны эцсээс 2.8%-аар чангарсан байна.

Тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт эхний 3 сарын байдлаар 0.6 хувьд хүрэв. Дотоодын эрэлт буурч, экспортын хэмжээ багассан нь эдийн засагт голчлон нөлөөлсөн байна. Ийнхүү Японы эдийн засаг 8 улирал дараалан өссөний эцэст удааширчээ.

Япон улсын иргэд аялал, авто машин болон өргөн хэрэглээний барааны зардлаа хэмнэж эхэлсэн учир өрхийн хэрэглээ 3 сар дараалан унав. Энэхүү тасралтгүй үргэлжилж буй өрхийн хэрэглээний бууралт тус улсын эдийн засгийг экспортоос хэт хамааралтай болгож байгаа юм. Үүнд АНУ-ын худалдааны бодлого ихээр нөлөөлж байна.

**БНХАУ:** Энэ оны 6-р сарын 1-ны өдөр БНХАУ-ын 234 компани "MSCI"-ийн олон улсын хөрөнгийн зах зээлийн жишиг индекст бүртгэсэн нь тус улсын голлох компаниудын хувьцааны ханш унахад нөлөөлсөн билээ.

АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргаан тус улсын хувьцааны ханшид сөргөөр нөлөөлөх төлөвтэй байгаа ажээ.

**Эх сурвалж:** Reuters, Troweprice

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,622.29	-2.01% ▼
Dow Jones	АНУ	25,316.53	2.77% ▲
S&P 500	АНУ	2,779.03	1.62% ▲
Nasdaq	АНУ	7,645.51	1.21% ▲
S&P/TSX	Канад	16,202.69	0.99% ▲
FTSE 100	Их Британи	7,681.07	-0.27% ▼
S&P/ASX 200	Австрали	6,045.20	0.91% ▲
Nikkei 225	Япон	22,694.50	2.36% ▲
Hang Seng	Хонг Конг	30,958.21	1.53% ▲

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	110.12
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	96.93
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	96.33
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	112.94
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.09
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.57
TDBM' 2020	USD	9.3%	106.31

### Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.046	0.04 ▲
Libor 3M	2.326	0.01 ▲
Libor 6M	2.489	0.01 ▲
Libor 1YR	2.740	0.02 ▲
US 6M Bond	2.100	0.02 ▲
US 2YR Bond	2.504	0.02 ▲
US 3YR Bond	2.641	0.02 ▲
US 5YR Bond	2.792	0.03 ▲
US 10YR Bond	2.953	0.04 ▲

### Валютын ханш /төг/

Валют	2018.06.08	Өөрчлөлт
USD	2,412.80	0.12% ▲
CNY	376.39	0.00% ▼
EUR	2,842.04	0.73% ▲
RUB	38.50	-0.90% ▼
KRW	2.24	-
JPY	22.06	0.45% ▲

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,299.15	0.44% ▲
Мөнгө /spot/	16.77	2.19% ▲
Зэс	330.00	6.74% ▲
Нүүрс	109.55	2.14% ▲
WTI газрын тос	65.6	-0.17% ▼
Brent газрын тос	76.37	-0.55% ▼
Байгалийн хий	2.93	-1.68% ▼

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018.IV	6.00%
Бодлогын хүү	2018.IV	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.IV	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.IV	12.80%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.IV	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.IV	19.30%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.IV	10.20%

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 47 компанийн 2,172.7 сая төгрөгийн 5,908,230 ширхэг хувьцаа арилжигдав.

“Алтайн зам” /AZH/ компанийн хувьцаа 74.78%-аар буюу хамгийн ихээр өсч 2,439 төгрөгт хүрч хаагдсан бол “Баян Алдар” /VIK/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 634.95 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 1,096 ширхэг үнэт цаас 111.4 сая төгрөгөөр арилжаалагджээ.

Компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр мөн л арилжаа явагдаагүй байна.

5-р сарын 31-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,487.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,024.71 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.44%-аар өссөн байна.

### MSE Индекс



Эх сурвалж: MSE

### Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

### Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	2,282.0
Зах зээлийн үнэлгээ	2,427,288.8

### Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,622.29	-2.01% ▼
MSE I индекс	9,471.75	-2.12% ▼
MSE II индекс	9,829.04	-2.34% ▼

### Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Шивээ Овоо	465,628	954,777,910
Фронттиер Лэнд Групп	1,822,673	546,801,900
Монгол базальт	809,262	322,685,128
ЛэндМН ББСБ	2,552,346	139,386,150
Таван Толгой	9,809	99,131,030

### Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Алтайн зам	4,263.00	74.78% ▲
Хөвсгөл алтан дуулга	141.50	14.99% ▲
Бэрх Уул	964.00	14.90% ▲
ЛэндМН ББСБ	55.94	9.24% ▲
Шарын гол	2,250.00	2.13% ▲

### Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
E-Trans logistics	70.00	-17.65% ▼
Materialimpex	9,000.00	-17.58% ▼
Frontier Lend Group	300.00	-13.65% ▼
HBOil	58.00	-13.43% ▼
Oloo	60.10	-10.29% ▼

### Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
БиДиСек	3,111,420,049
ТиДиБи Капитал	218,735,826
Гаүли	191,510,296
Мирэ Эссет Секьюритис Монгол	185,608,378
Стандарт Инвестмент	160,544,055

### Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	587.25	624,641
Таван толгой	9,900.00	521,385
МИК	10,500.00	217,448
Говь	22,580.00	176,149
Сүү	222.23	76,447

## ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-15/08/20-A0295-14.5	8	837,200	104,650	104,650	156	14.500%

Компанийн бондын хоёрдогч зах зээл

№	Name	Volume	Turnover /MNT/	Minimum /MNT/	Maximum /MNT/	Weeks	Annual interest rate
1	SUUB-BD-29/06/18-C0006-17.5	76	7,600,000	100,000	100,000	52	17.500%
2	SUUB-BD-29/06/18-C0006-17.5	10	1,000,000	100,000	100,000	52	17.500%

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	ERS	Монгол алт ХК	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
2	TEE	Тээвэр дархан ХК	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
3	TTL	Таван Толгой ХК	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.04.27-с	Тодорхойгүй
4	EER	Ариг гал ХК	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с	Тодорхойгүй
5	BDL	Могойн гол ХК	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	Тодорхойгүй	Тодорхойгүй
6	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с	Тодорхойгүй
7	TAL	Талын гал ХК	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
8	AND	Анд-Энерги ХК	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
9	SUL	Жуулчин дюти фрий ХК	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с	Компанийн байранд
10	GTL	Гутал ХК	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с	Тодорхойгүй
11	BNG	Баянгол зочид буудал ХК	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с	Компанийн байранд
12	APU	АПУ ХК	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
13	BTG	Баянтээг ХК	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
14	MIE	Материалимпекс ХК	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
15	HRD	Хүрд ХК	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор	Тодорхойгүй
16	SUU	Сүү ХК	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
17	MNP	Монгол шуудан ХК	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
18	MMX	Махимпекс ХК	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с	Компанийн байранд
19	TCK	Талх чихэр ХК	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с	Компанийн байранд
20	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тодорхойгүй
21	ADL	Адуун чулуун ХК	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	Тодорхойгүй	ҮЦТХТ-ийн данс
22	ТАН	Тахь-ко ХК	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
23	UBH	Улаанбаатар хивс ХК	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с	ҮЦТХТ-ийн данс
24	GOV	Говь ХК	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов	Компанийн байранд
25	HRM	Гермес центр ХК	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” МХБ-ийн 5,736 дахь удаагийн арилжааг нээлээ

Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, Монгол улсад ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” Монголын хөрөнгийн биржид үнэт цаасаа бүртгүүлж, үнэт цаасны давхар бүртгэл Монголын хөрөнгийн зах зээлд нэвтэрч буй онцгой үйл явдлыг тохиолдуулан 2018 оны 6 дугаар сарын 04-ний өдөр Монголын хөрөнгийн биржид үнэт цаасны 5,736 дахь удаагийн арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохих ёслол боллоо.

2018 оны 6 дугаар сарын 06-ний өдөр тус компани олон нийтэд зориулсан Үнэт цаасны танилцуулгаа хийлээ.

Монголын Хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх зөвшөөрлөө авснаас хойш “Erdene Resource Development” компанийн хувьцааны ханш Торонтогийн Хөрөнгийн биржид гурав орчим хувиар буурсан байна. Тус компани Монголын Хөрөнгийн биржид дөрвөн сая ширхэг хувьцааг тус бүрийг нь 640 төгрөгөөр үнэлэн олон нийтэд санал болгож, нийт 2.56 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр төлөвлөөд байгаа ажээ. Энэхүү хөрөнгийг хайгуулын өрөмдлөг, нөөцийн тооцоолол, техникийн судалгаа хийж гүйцэтгэхэд зарцуулах юм байна. Монголд гаргах хувьцаанаасаа 101,100 ширхгийг үйл ажиллагаа явуулж буй Баянхонгор аймгийн хоёр сумын иргэдэд нэр зааж эзэмшүүлэх бол үлдэх 3.89 сая ширхэг хувьцааг тогтоосон үнээр олон нийтэд санал болгох ажээ. “Erdene Resource Development”-ийн зах зээлд арилжаалж байгаа нийт хувьцааных нь тоо 146.4 сая ширхэг юм байна.

Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалгыг 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс 14-ний өдрийн 15 цаг хүртэл Монголын хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан хүлээн авна.

“Erdene Resource Development” компани Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй болсноор Монголд үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компанийн хувьцаанд монгол иргэд хөрөнгө оруулах боломж нээгдэж байгаа юм.

**Эх сурвалж:** MSE.mn, BloombergTv.mn

### СЗХ: “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг 23 тэрбум төгрөг болголоо

Монголын Хөрөнгийн биржийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 23 тэрбум төгрөг болгосон талаар Санхүүгийн зохицуулах хороо мэдээллээ. Мөн нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн байна. 2017 онд Сангийн яам улсын төсвөөс ийм хэмжээний санхүүжилт олгосныг хувь нийлүүлсэн хөрөнгөд нь ийнхүү нэмж тусгажээ. Засгийн газар Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах хүрээнд Монголын Хөрөнгийн биржийн хувьцааны тодорхой хэсгийг Лондоны Хөрөнгийн биржид төлөх өрд тооцон хувьцаагаар солих санал тавьсан юм. Харин үлдсэн хувьцааг Монголын Хөрөнгийн бирж болон гадаадын нэр хүнд бүхий Хөрөнгийн биржээр нээлттэй арилжихаар засгийн газар шийдвэрлэсэн юм. Одоо УИХ-ын шийдвэр хүлээгдэж байна.

Үүнээс гадна Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит хуралдаанаар “Гэрэгэ менежмент” компанид хөрөнгө оруулалтын менежментийн, “Хост Рок” компанид даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### “Монгол шир” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Монгол шир” ХК-ийн 2017 оны 12 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох тухай шийдвэр гаргасныг үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон Санхүүгийн зохицуулах хороо “Монгол Шир” ХК-ийг үнэт цаасны бүртгэлээс хассан тул хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй эсхүл энэхүү шийдвэрийн эсрэг саналтай байсан саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдэд дараах эрх үүссэнийг мэдэгдэж байна. Үүнд:

1. “Монгол шир” ХК-ийн хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшиж байгаа хувьцааг нэг бүрийг нь 2714 /хоёр мянга долоон зуун арван дөрөв/ төгрөгөөр эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй. Энэхүү эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн харьяа гишүүн үнэт цаасны компани эсвэл “БиДиСЕК ҮЦК” ХК болон “Монгол шир” ХК-д хандана уу.
2. Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүний дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг авалгүйгээр компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргах эрхтэй.
3. Шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаа: 2018 оны 7-р сарын 24-ний өдөр.

**Эх сурвалж:** MSE.mn

### “Сүү” ХК болон “Монгол шуудан” ХК-ийн 2017 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа

“Сүү” ХК-ийн 2017 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 2.70 төгрөг тараасныг 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдөр, “Монгол Шуудан” ХК-ийн 2017 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 3.31 төгрөг тараасныг 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

**Эх сурвалж:** SCHCD.mn

### ҮЦТХТ: V сард шинээр нээсэн 4,395 дансны 15 хувийг “Бумбат алтай” ҮЦК нээжээ

2018 оны тавдугаар сард Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нийт 4,395 шинэ данс, 970 холболтын данс нээсэн байна. Үүнээс 15 орчим хувийг “Бумбат Алтай” Үнэт цаасны компани дангаараа нээжээ.

“Бумбат Алтай” Үнэт цаасны компани тавдугаар сард IPO гаргасан “Монгол базальт” компанийн андеррайтераар ажилласан юм. Мөн энэ ондоо багтаан хэд хэдэн шинэ бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэхээр бэлдэж байгаа талаараа мэдээлээд байна. Харин үнэт цаасны төвлөрлийн судалгаанаас харахад хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй 315 компанийн 58 компанийнх нь 15-аас дээш хувийг жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Ялангуяа сүүлийн нэг жилд шинээр хөрөнгийн зах зээлд бүртгэгдсэн дөрвөн компанийн 25-40 хувийг давхардсан тоогоор 8225 хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа юм. Мөн нийт 315 компанийн 21 компани нь 100 хувь Төрийн мэдэлд байгаа аж.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Xanadu Mines” компани “Хармагтай” ордын “Зараа” талбайд хийсэн хайгуулын дүнгээ шинэчлэв

Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Xanadu Mines” компани “Хармагтай” ордын “Зараа” талбайд хийсэн хайгуулын дүнгээ шинэчлэн танилцууллаа. Энэхүү талбайгаас есөн метрийн гүнд тонн хөрснөөс 6.6 грамм алт, 24 метрийн гүнд 0.18 хувийн агууламжтай зэсийн илэрц олсон байна. Мөн зарим хэсэгт дөрвөн метрийн гүнд тонн хөрснөөс 2.42 грамм алт, 27 метрийн гүнд 0.07 хувийн зэсийн илэрц тогтоожээ.

“Xanadu Mines”-ийн Гүйцэтгэх захирал Андрию Стюарт “Бид “Зараа” хэмээх энэхүү шинэ талбайн хайгуулын үр дүнд хурдацтай өөрчлөлт гарч байгаад сэтгэл хангалуун байна” гэж мэдэгдсэн юм.

Австралийн Хөрөнгийн биржийн арилжаа мягмар гарагт эхлэх үед “Xanadu Mines”-ийн хувьцааны ханш хэлбэлзэлгүй, 0.19 австрали доллар хэвээр байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлого”-ыг батлав

Засгийн газрын хуралдаанаар “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлого”-ыг баталлаа. Ингэснээр газрын тосны салбарын хүний нөөц, ажиллах хүчний чадавх сайжирч, гадаадаас авах ажиллах хүчний тоо буурна гэж тооцсон байна. Мөн хөрөнгө оруулалт нэмэгдэж, гадагш чиглэсэн хөрөнгийн урсгалыг багасган, үндэсний Төрийн болон Төрийн өмчийн оролцоотой компани бий болж, орон нутагт орох өгөөжийг нэмнэ гэж үзэж байгаа юм байна. Монгол Улс Энэтхэгийн Засгийн газрын нэг тэрбум долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахаар болсон юм. Үүнтэй холбоотойгоор боловсон хүчнээ чадавхжуулах шаардлагатай байгаа гэдгийг салбарын судлаачид дүгнэж байна.

Одоогийн байдлаар Монголд газрын тосны хайгуулын 275 талбайд 21 компани бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулаад байгаа аж. Хайгуулын дүнд гурван талбайд 333 сая тонн баталгаат зэрэглэлийн нөөц тогтоожээ. Ингэснээр Монгол Улс газрын тосны нөөцөөрөө дэлхийд 33 дугаарт бичигдэж байгаа талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээлсэн юм. Монгол Улсын хэмжээнд хоногт дунджаар 2,742 тонн газрын тос олборлож, 2,803 тонн газрын тос экспортолж байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Нүүрсний үнийг хязгаарлах БНХАУ-ын бодлого үр дүнгээ өгөхгүй байна

Тасралтгүй нэмэгдэж байгаа нүүрсний үнийг өсгөхгүй байх БНХАУ-ын Засгийн газрын бодлого тодорхой үр дүнд хүрэхгүй байна. Чинхуандаогийн боомтод нүүрсний үнийг 89 ам.доллар буюу 570 юань байх нь хамгийн тохиромжтой түвшин гэж тус улсын Засгийн газар үзэж байгаа аж. Хэдий тийм боловч одоогоор энэ түвшнээс 100 гаруй юаниар өндөр байгаа юм. Чинхуандаогийн боомтод зургаадугаар сарын дөрвөнөөр эцэслэсэн долоо хоногт нүүрсний спот ханш 4.2 хувиар өсөж, 667 юаньд хүрчээ. Энэ нь гуравдугаар сараас хойших хамгийн өндөр түвшинд тооцогдож байгаа бөгөөд тавдугаар сард нүүрсний эрэлт нэмэгдэж, агуулах дахь нөөцийн хэмжээ түүхэн доод түвшинд хүрсэнтэй холбоотой гэдгийг “Daiwa Capital Markets”-ийн шинжээчид онцолж байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Монголбанк “Эх орныхоо алтыг эрдэнэсийн сандаа” аяныг эхлүүллээ

Монголбанкнаас “АЛТ-2” үндэсний хөтөлбөрийн хүрээнд таван сарын хугацаатай “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аян эхлүүллээ.

Энэхүү аяны зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагууд олборлосон алтаа Монголбанк болон арилжааны банкуудад худалдаж, алт тушаалтыг нэмэгдүүлэх, олон нийтийн дунд алт худалдан авах үйл ажиллагааны талаар сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, холбогдох хууль, журмыг таниулахад чиглэж буйг албаныхан онцлов.

Мөн Монгол Улсын гаалиар зөвшөөрөлгүй алт гаргах үйлдлийг бууруулах, хариуцлагатай уул уурхайг дэмжих, тэдний үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, Монголбанкны худалдан авч буй алтны үнийн талаар болон бусад мэдээллийг олон нийт, байгууллагад хүргэх, таниулах шаардлагатай гэж үзэж байгаа аж. Дээрх аяны үр дүнд Монголбанкны алт худалдан авалт болон Монгол Улсын гадаад валютын нөөц нэмэгдэж, төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоо сайжрах юм байна.

“Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аян нь алт олборлогч, үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд, төв болон орон нутгийн бусад холбогдох байгууллагууд, иргэд рүү чиглэх бөгөөд ирэх 10 дугаар сарын 30-ныг хүртэл үргэлжлэх юм.

Тус аяныг Монголбанк болон орон нутаг дахь салбар, хэлтэс, арилжааны банкууд, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Стандарт хэмжил зүйн газар, төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран зохион байгуулж байна.

**Эх сурвалж:** Montsame.mn

### “Оюу Толгой” ХХК-ийн ТУЗ цахилгаан станцын судалгааны санхүүжилтийг батлах эсэхийг хэлэлцэнэ

“Оюу Толгой”-ийн эрчим хүчний урт хугацааны нийлүүлэлтийг баталгаажуулах шаардлагатай хугацаа давчуу болж байгаа талаар “Оюу Толгой” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар “Rio Tinto”-ийг төлөөлөн томилогдсон Армандо Торез ажилтнууддаа хандан илгээсэн захидалдаа дурджээ. Тийм учраас лхагва гарагт “Оюу Толгой” ХХК-ийн ТУЗ-ийн хурлаар нэг тэрбум ам.доллараар үнэлэгдэж байгаа цахилгаан станцын төслийн судалгааны санхүүжилтийг батлах эсэх талаар хэлэлцэнэ гэж байв. Эргэн сануулахад, Засгийн газар болон “Оюу Толгой” ХХК-ийн хооронд 2014 онд байгуулсан “Өмнөд бүсийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах” гэрээг өнгөрсөн хоёрдугаар сард цуцалсан юм. Ингэснээр хөрөнгө оруулалтын гэрээнд заасны дагуу “Оюу Толгой” ХХК дөрвөн жилийн дотор эрчим хүчний эх үүсвэрээ дотоодос бүрэн хангах үүрэг хүлээж байгаа аж. Харин “Тавантолгой”-ийн цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэх хувилбарыг Монголын тал санал болгосон юм. Хэдий тийм боловч “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Мөнхбаатарын мэдээлснээр “Оюу Толгой” төслийн талбайд цахилгаан станц барих хувилбарыг хөрөнгө оруулагч “Rio Tinto” санал болгож байгаа” юм байна.

Үүнээс гадна “Цахилгаан станц барих асуудлаар 2018 оны эцсээр эцсийн шийдвэрт хүрэх төлөвтэй байна”... “Мөн эрчим хүч экспортлох бизнест оролцохгүй, зөвхөн “Оюу Толгой”-ийн эрчим хүчний хэрэгцээг хангах боломжийг эрэлхийлж байна” гэж “Turquoise Hill Resources” компанийн Гүйцэтгэх захирал, “Оюу Толгой” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн Жеффри Тайгесен 2017 оны санхүүгийн тайлантай холбоотой теле хурлынхаа үеэр мэдээлж байсан юм.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## БУСАД МЭДЭЭ

### Татварын багц хуульд тусгасан хөрөнгө оруулалтыг дэмжих онцлох 3 заалт

Татварын багц хуулийн шинэчлэлээр хувь хэмжээг бууруулж байгаа ч төсөвт дарамт болохгүй гэж Сангийн яам мэдээллээ. Харин дунд хугацаандаа татварын орлого 13-14 хувиар нэмэгдэнэ гэж үзэж байна. Учир нь Татварын багц хуулийн төсөлд хөрөнгө оруулалтыг дэмжсэн хэд хэдэн өөрчлөлтийг тусгаж өгчээ. Тухайлбал, барилга байгууламжийн элэгдэл тооцох хугацааг 25 жил болгож бууруулсан байна. Хоёрдугаарт алдагдал шилжүүлэх хугацааг салбараар нь ялгахгүй бүгд таван жил болгожээ. Ингэснээр хөрөнгө оруулалт ихээр хийгдэж байгаа үед алдагдлаа тооцохгүй дараагийн жилүүдэд тооцох боломж бий болж байна. Үүнээс гадна хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор Хөрөнгийн биржээр гаргасан хувьцаа, өрийн бичиг, зээлийн хүүгийн орлогыг 20-иос таван хувь болгон бууруулах заалт оруулжээ. Мөн Монгол Улсын аж ахуйн нэгж гадаадад үйл ажиллагаа явуулж татвар төлсөн бол Монгол Улсын татвараас хасаж тооцохоор болсон гэж Сангийн яам мэдээллээ.

Татварын багц хуулийн төслийг Засгийн газар УИХ-д өргөн бариад байгаа бөгөөд энэ хаврын чуулганаар Татварын багц хуулийг хэлэлцэж батлах төлөвтэй байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### ГЕГ: 2018 оны эхний 5 сард экспорт 14.6 хувиар, импорт 45.5 хувиар өссөн

2018 оны эхний таван сарын байдлаар Монгол Улсын гадаад худалдааны бараа эргэлт 5.06 тэрбум ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 26 хувиар өссөн байна. Экспорт 14.6 хувиар, импорт 45.5 хувиар тус тус өссөн талаар Гаалийн ерөнхий газар мэдээллээ. Үүнээс гадна Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болж хэрэгжиж эхэлснээс хойш хоёр жилийн хугацаа өнгөрлөө. Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд Монголын тал 97 бүлгийн 5700 нэр төрлийн бараа, Японы тал 97 бүлгийн 9300 нэр төрлийн барааг импортын гаалийн тарифыг шууд чөлөөлөх, эсвэл 10 жилийн хугацаанд үе шаттайгаар бууруулж байгаа юм. Монголоос Японы зах зээлд гаргаж байгаа экспортын 80 орчим хувийг ноос, ноолууран бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа бол үлдсэн нь өлөн гэдэс, муур нохойны хоол, боловсруулсан хөнгөн цагаан зэрэг багтаж байгаа талаар МҮХАҮТ мэдээлсэн юм.

2017 онд Японы "Ханаду" нисэх онгоцны буудалд салбар дэлгүүрээ нээсэн "Говь" ХК-ийн хувьд Японы зах зээлд экспортолж байгаа ноолууран бүтээгдэхүүний хэмжээ өссөн байна. "Гаалийн тарифын хөнгөлөлт эдэлж байгаа нь хямд өртөгтэй БНХАУ-ын ноолууран бүтээгдэхүүнүүдтэй өрсөлдөхөд гол давуу тал болж байна" гэж "Говь" ХК-ийн борлуулалт хариуцсан дэд захирал Л.Ариун онцолсон байна.

Харин импортын тухайд гаалийн тарифын хөнгөлөлт эдэлж байгаа "Таван богд" ХХК-ийн тухайд зөвхөн I улиралд л гэхэд нийт шинэ автомашины импортын 50 орчим хувь буюу 414 автомашиныг Монголын зах зээлд оруулж ирсэн байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn



### Монголбанк: 2018 оны эхний 4 сард ОХУ-тай хийх худалдаа 50 хувиар өссөн

2018 оны эхний дөрвөн сарын байдлаар ОХУ-тай хийсэн худалдаа жилийн өмнөхөөс 50 хувиар өсөж, 503 сая ам.долларт хүрсэн гэж Монголбанк мэдээллээ. Ингэснээр Монголд ОХУ-ын бараа эргэлтийн хэмжээ БНХАУ-ын дараа хоёрдугаарт эрэмбэлэгдэж байна. 2017 оны бүтэн жилийн дүнг авч үзвэл хоёр улсын худалдаа 1.4 тэрбум ам.долларт хүрчээ. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь Монгол Улсын нийт экспортыг 12.5 нэгж хувиар өсөхөд нөлөөлсөн гэж Монголбанк дүгнэсэн байна. Үүнээс онцолбол 2018 оны I улиралд жоншны экспорт өнгөрсөн оны мөн үеэс хоёр дахин өсөж, 25 сая ам.долларт хүрсэн байна. Үүний тал хувийг ОХУ-д экспортолжээ. Үүнээс гадна энэ онд Монгол Улсад цөмийн шинжлэх ухаан, технологийн төв байгуулах чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийг Монгол Улсын Цөмийн энергийн комисс болон ОХУ-ын Атомын энергийн "Росатом" улсын корпораци байгуулаад байгаа юм.

ОХУ-ын Элчин сайд И.К.Азизовын мэдээлснээр зургаадугаар сарын 9, 10-ны өдөр БНХАУ-ын Чиндао хотод болох ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтаар гурван улсын Төрийн тэргүүн нар уулзаж, Эдийн засгийн коридор байгуулах төслийн ажлын хэсгүүдийн боловсруулсан саналыг батлах хүлээлттэй байна. Мөн хоёр улсын худалдааны эргэлт ойрын жилүүдэд хоёр тэрбум ам.долларт хүрнэ гэж итгэж байгаагаа ОХУ-ын тал илэрхийлжээ.

2016 онд Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Эдийн засгийн коридорт хамрагдах 32 төслийн жагсаалтыг баталсан юм. Үүнээс 13 нь тээврийн, ялангуяа төмөр замын тээврийн салбарт хэрэгжих төслүүд байна. Гурван улсын төмөр замын төв, хойд, баруун, зүүн дөрвөн коридор байгуулах ажлыг тусгажээ.

Иргэдийн 18.8 хувь нь хөрөнгийн биржийн арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсан гэж хариулсан бол 51.0 хувь нь үгүй, 30.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан. Үүнийг жилийн өмнөх судалгаанд оролцогсдын 14.0 хувь нь арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсантай харьцуулбал иргэдийн хөрөнгийн зах зээлд оролцох сонирхол 4.8 пунктээр өссөн байна. Бүрэн дундаас дээш боловсролтой иргэдийн арилжаанд оролцох сонирхол доогуур боловсролтой иргэдээс 40 хувиар өндөр байна. Эрэгтэйчүүдийн арилжаанд оролцох сонирхол эмэгтэйчүүдээс 1.7 дахин өндөр байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдлыг баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээжгүй болно.